



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2021 08 САР
СТАТИСТИКИЙН
ТАНИЛЦУУЛГА



 www.ubstat.mn

 www.facebook.com/StatisticUlaanbaatar

 www.1212.mn



АГУУЛГА

Хуудасны
дугаар

	НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2017-2021 ОН	1
	НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР	2
	НИЙГМИЙН ДААТГАЛ	4
	ЭРҮҮЛ МЭНД	8
	ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ	13
	ГЭМТ ХЭРЭГ	19
	ТӨСӨВ	23
	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	27
	АЖ ҮЙЛДВЭР	37
	ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙ	43
	ГАЗАР ТАРИАЛАН	46

Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний 8 сард

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2021
Шинээр төрсөн хүүхэд		хүн	↓ 24 986 ^{8.3}	↑ 26 977 ^{7.1}	↑ 27 266 ^{1.1}	↓ 26 708 ^{2.0}	↓ 24 751 ^{7.3}
Халдварт өвчнөөр өвчлөгчид		хүн	↓ 19 546 ^{39.1}	↓ 15 645 ^{20.0}	↑ 16 314 ^{4.3}	↓ 11 071 ^{32.1}	↑ 141 508 ^{12.8**}
Бүртгэгдсэн гэмт хэрэг		тоо	↑ 12 807 ^{0.9}	↑ 18 158 ^{4.8}	↓ 15 329 ^{15.6}	↓ 11 607 ^{24.3}	↓ 9 499 ^{18.2}
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		хувь	↑ 1.3 ^{1.9}	↓ -0.9 ^{2.2}	↑ 0.4 ^{1.5}	↓ -1.1 ^{1.5}	↑ 0.1 ^{1.2}
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	төгрөг	↑ 2 444 ^{11.6}	↑ 2 464 ^{0.8}	↑ 2 671 ^{8.4}	↑ 2 849 ^{6.7}	2 849 ^{0.0}
	Юань (БНХАУ)	төгрөг	↑ 366 ^{11.3}	↓ 360 ^{1.8}	↑ 378 ^{5.1}	↑ 411 ^{8.7}	↑ 440 ^{7.0}
	Рубль (ОХУ)	төгрөг	↑ 41 ^{21.8}	↓ 37 ^{9.4}	↑ 41 ^{9.4}	↓ 39 ^{5.1}	39 ^{0.0}
Нийслэлийн төсвийн орлого		тэрбум төгрөг	↓ 425.4 ^{20.8}	↑ 551.3 ^{29.6}	↑ 578.7 ^{5.0}	↓ 520.5 ^{10.1}	↑ 709.5 ^{36.3}
Нийслэлийн төсвийн зарлага		тэрбум төгрөг	↓ 555.1 ^{9.9}	↑ 720.5 ^{29.8}	↑ 779.9 ^{8.2}	↑ 787.4 ^{1.0}	↓ 723.5 ^{8.1}
Агаарын дундаж температур		°C	15.8	17.5	15.7	16.0	15.9

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан


 Эерэг хандлага, өөрчлөлт

 Сөрөг хандлага, өөрчлөлт

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2020 I-VIII					2021 I-VIII				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	317	Баянгол	7 734	Налайх	55	322	Баянгол	7 935	Налайх	57
			Чингэлтэй	1 712	Багануур	47		Чингэлтэй	1 709	Багануур	48
			Сүхбаатар	704	Багахангай	32		Сүхбаатар	699	Багахангай	33
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	11	Сонгинохайрхан	12	Хан-Уул	5	11	Налайх	21	Сүхбаатар	9
			Налайх	12	Сүхбаатар	3		Багануур	18	Хан-Уул	6
			Баянгол	9	Багахангай	-		Сонгинохайрхан	12	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	76	Налайх	75	Сүхбаатар	45	954	Хан-Уул	822	Багануур	538
			Багануур	69	Хан-Уул	41		Баянзүрх	805	Сонгинохайрхан	488
			Сонгинохайрхан	67	Багахангай	21		Сүхбаатар	778	Багахангай	399
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	66	Чингэлтэй	64	Багануур	11	98	Чингэлтэй	117	Багануур	16
			Сүхбаатар	56	Налайх	10		Хан-Уул	63	Налайх	16
			Хан-Уул	42	Багахангай	7		Сүхбаатар	59	Багахангай	8
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	119	Сүхбаатар	196	Сонгинохайрхан	79	97	Сүхбаатар	131	Налайх	67
			Баянзүрх	136	Багахангай	57		Баянзүрх	102	Багануур	54
			Чингэлтэй	126	Багануур	53		Чингэлтэй	102	Багахангай	50

Тайлбар: * промилль ** продицмил

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ


мянга	=1000
сая	=10 ⁶
тэрбум	=10 ⁹
их наяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



НИЙГМИЙН ДААТГАЛ (2021 оны эхний 8 сард)

НИЙГЭМНИЙ
ДААТГАЛ


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, тэрбум төгрөг




* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

→ НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД


Албан журмаар даатгуулагчид



Сайн дураар даатгуулагчид



→ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИД ХАМРАГДАГЧИД




НИЙГМИЙН ДААТГАЛ

2021 оны эхний 8 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 32.5 мянган байгууллага, 655.9 мянган иргэн хамрагдаж, 1099.4 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын сангуудаас олгосон ба өмнөх оны мөн үеэс 208.1 (23.3%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 477.2 мянга (72.8%) нь аж ахуйн нэгж байгууллагын, 115.8 мянга (17.7%) нь төсөвт байгууллагын, 62.8 мянга (9.6%) нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчид өмнөх оны мөн үеэс 16.4 мянган (2.5%) даатгуулагчаар өссөн байна.

Нийслэлийн нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 8 сард нийт 833.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 71.6 тэрбум төгрөгөөр (9.4%) илүү бүрдсэн ба өмнөх оны мөн үеэс 252.3 (43.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөг, сараар




Хүснэгт 3. Нийслэлийн нийгмийн даатгалын сангийн орлого, дүүргээр, сая төгрөг

Дүүрэг	Орлого			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нийслэлийн дүн	761 594.7	833 162.6	109.4	71 567.8
Багануур	9 428.8	10 370.8	109.9	942.0
Багахангай	1 109.3	1 258.9	113.5	149.6
Баянгол	134 478.1	146 232.9	108.7	11 754.8
Баянзүрх	103 470.6	108 150.0	104.5	4 679.4
Налайх	6 778.3	6 528.0	96.3	-250.3
Сонгинохайрхан	53 641.3	53 970.3	100.6	329.0
Сүхбаатар	163 555.0	185 769.7	113.6	22 214.8
Хан-Уул	125 283.4	139 476.1	111.3	14 192.6
Чингэлтэй	163 849.9	181 405.8	110.7	17 556.0

Нийгмийн даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 90.1 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 4.6 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 4.4 хувь нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний (YOMШӨ) даатгалын санд, 0.9 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 2. Даатгалын сангийн зарлага, хувиар, VIII сарын эцэст



Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын 82.3 хувийг тэтгэврийн, 9.7 хувийг тэтгэмжийн, 3.7 хувийг ҮОМШӨ-ний, 4.3 хувийг ажилгүйдлийн даатгалын санд тус тус эзэлж байна.

Зураг 3. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо



2021 оны эхний 8 сард тэтгэврийн даатгалын сангаас 904.2 тэрбум төгрөгийн зарлага гарснаас 143.8 мянган (өндөр насны тэтгэвэр авагч) хүнд 533.0 тэрбум (58.9%) төгрөгийг, 24.1 мянган (хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авагч) хүнд 60.9 тэрбум (6.7%) төгрөгийг, 12.3 мянган (цэргийн тэтгэвэр авагч) хүнд 67.3 тэрбум (7.4%) төгрөгийг, 7.1 мянган (тэтгэвэр авагч) хүнд 18.7 тэрбум (2.1%) төгрөгийг тус тус олгосон байна. Үлдсэн 224.1 тэрбум (24.8%) төгрөгийг бусад зардалд зарцуулжээ.

Харин тэтгэмжийн даатгалын сангаас 106.6 тэрбум төгрөгийн зарлага гарснаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан 49.1 мянган хүнд 8.9 тэрбум (8.4%) төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 26.6 мянган эхэд 51.6 тэрбум (48.4%) төгрөгийг, 4.7 мянган иргэний ар гэрт 4.7 тэрбум (4.4%) төгрөгийн оршуулгын тэтгэмж, 41.4 тэрбум (38.8%) төгрөгийг бусад зардалд тус тус олгосон байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



ЭРҮҮЛ МЭНД (2021 оны эхний 8 сард)

ЭРҮҮЛ МЭНД

Амаржсан эх



2020 VIII 26 424

2021 VIII 24 535

7.0%



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2020 VIII 11 071

2021 VIII 141 508

12.8 дахин



Нялхсын эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2020 VIII

11.3

2021 VIII

10.9

5 хүртэлх насны хүүхдийн
эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2020 VIII

12.7

2021 VIII

12.6

ЭРҮҮЛ МЭНД


Нийслэлийн хэмжээнд 2021 оны эхний 8 сард 24535 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 1889 (7.0%) төрөлтөөр буурсан байна. Нийт төрөлтийн 15261 (62.2%) нь НЭМГ-ын харьяа эмнэлэгт, 9274 (37.8%) нь нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ЭМЯ-ны харьяа улс болон хувийн хэвшлийн эмнэлэгт амаржсан байна. Нийт амаржсан эхчүүдийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байна.

Хүснэгт 4. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний 8 сард

Үзүүлэлт	2019 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	$\frac{2021}{2020}$ %
Амаржсан эхийн тоо	27 028	26 424	24 535	-7.0
Гэрийн төрөлт	87	89	68	-23.0
Хяналтгүй төрөлт	163	134	72	-46.0
Амьд төрсөн хүүхэд	27 266	26 708	24 751	-7.0
Эхийн эндэгдэл	6	10	30	3.0**
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	350	301	269	-10.6
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	12.8	11.3	10.9	-

2021 оны эхний 8 сард 24751 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 1957 (7.0%) хүүхдээр цөөн байна. Төрсөн нийт хүүхдийн 3577 (14.5%) нь бусад аймгийн харьяат эхчүүдээс мэндэлжээ.


Зураг 4. Амьд төрсөн хүүхэд, дүүргээр



Төрсөн нийт хүүхдийн 12787 (51.7%) нь эрэгтэй, 11964 (48.3%) нь эмэгтэй хүүхэд байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 2 ихэр 344, 3 ихэр 4 байна. Мөн 3.3 хувь нь 2500 граммаас бага жинтэй, 0.5 хувь нь төрөлхийн гажигтай төржээ.

Амьгүй төрөлтийн 140 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор буурсан байна. Амьгүй төрөлт Баянгол, Сүхбаатар, Багахангай, Багануур дүүрэгт хотын дунджаас өндөр байна.


Зураг 5. Хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох), дүүргээр, эхний 8 сард



2021 оны эхний 8 сард бүртгэгдсэн нялхсын эндэгдлээс Сонгинохайрхан дүүрэгт 56 (20.8%) нь, Баянгол дүүрэгт 30 (11.2%) нь, Баянзүрх дүүрэгт 41 (15.2%) нь, Чингэлтэй дүүрэгт 19 (7.1%) нь, Хан-Уул дүүрэгт 18 (6.7%) нь, Сүхбаатар дүүрэгт 13 (4.8%) нь, Налайх дүүрэгт 13 (4.8%) нь, Багануур дүүрэгт 7 (2.6%) нь, бусад аймгийн харьяат 72 (26.8%), Багахангай дүүрэгт бүртгэгдээгүй байна.

Нийслэлд 2021 оны эхний 8 сард 141508 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 130437 (14.3 дахин их) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 877.5 продицимилээр тус тус өссөн байна.

Зураг 6. Халдварт өвчнөөр өвчлөгчид, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварт өвчний төрлөөр нь авч үзвэл амьсгалын замын цочмог халдварт өвчин 138123 (97.6%), бэлгийн замаар дамжих халдварт өвчин 2659 (1.9%), гэдэсний халдварт өвчин 245 (0.2%), зоонозын халдварт өвчин 9 (0.01%), бусад халдварт өвчин 469 (0.29%) байна.

2021 оны эхний 8 сард **Коронавируст халдвар /COVID-19/-ын** 137077 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 96.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 5. Нийслэлд гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний 8 сард

Төрөл	Хэмжих нэгж	2019 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	Өсөлт, бууралт 2021/2020	
					тоо/пункт	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	бодит тоо	16 314	11 071	141 508	130 437	12.8**
	10000 хүнд	114.0	76.0	953.5	877.5	
Үүнээс:						
Вируст гепатит	бодит тоо	151	133	42	-91	-68.4
	10000 хүнд	1.1	0.9	0.3	-0.6	
Цусан суулга	бодит тоо	3 168	1 496	214	-1 282	-85.7
	10000 хүнд	22.1	10.3	1.4	-8.9	
Салхин цэцэг	бодит тоо	4 745	1 104	44	-1 060	-96.0
	10000 хүнд	33.2	7.6	0.3	-7.3	
Гахай хавдар	бодит тоо	28	27	4	-23	-85.2
	10000 хүнд	0.2	0.2	0.01	-0.19	
Сальмонеллөз	бодит тоо	202	140	12	-128	-91.4
	10000 хүнд	1.4	1.0	0.1	-0.9	
Улаан эсэргэнэ	бодит тоо	503	124	4	-120	-96.8
	10000 хүнд	3.5	0.9	0.03	-0.87	
Хоолны хордлого	бодит тоо	655	73	9	-64	-87.7
	10000 хүнд	4.6	0.5	0.1	-0.4	
Ёлом	бодит тоо	74	58	3	-55	-94.8
	10000 хүнд	0.5	0.4	0.02	-0.38	
Бруцеллөз	бодит тоо	12	8	1	-7	-87.5
	10000 хүнд	0.1	0.1	0.01	-0.09	
Гар хөл амны өвчин	бодит тоо	867	212	10	-202	-95.3
	10000 хүнд	6.1	1.5	0.1	-1.4	
Тэмбүү	бодит тоо	2 048	2 679	1 426	-1 253	-46.8
	10000 хүнд	14.3	18.4	9.6	-8.8	
Гонококкт халдвар	бодит тоо	1 152	1 615	664	-951	-58.9
	10000 хүнд	8.1	11.1	4.5	-6.6	
Трихомониаз	бодит тоо	1 024	1 288	563	-725	-56.3
	10000 хүнд	7.2	8.8	3.8	-5.0	
Сүрьеэ	бодит тоо	1 519	1 526	993	-533	-34.9
	10000 хүнд	10.6	10.5	6.7	-3.8	
ДОХ	бодит тоо	12	11	6	-5.0	-45.5
	10000 хүнд	0.1	0.1	0.04	-0.06	
Өөр бүлэгт ангилсан өвчний шалтгаан болох коронавирус – (Covid 19)	бодит тоо	-	301	137 077	136 776	455.4**
	10000 хүнд		2.1	923.6	921.5	

Ойлголт, тодорхойлолт:

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



ЦАГ УУР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ (2021 оны 8 дугаар сард)



Агаарын температур °C (Үнэмлэхүй их/бага)



28.4°C

Хамгийн дулаан хэм



5.9° C

Хамгийн хүйтэн хэм

Гал түймрийн тоо



2021 VIII 994 ^{25.3%↓}

2020 VIII 1 330

Хүний үйл ажиллагаатай холбоотой осол



1

Үйлдвэрийн осол



97

Бусад

Байгаль орчны зөрчил



157

ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэлийн агаарын дундаж хэм 2021 оны 8 дугаар сард дунджаар 15.9⁰С байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.1⁰С-аар бага, олон жилийн дундажтай харьцуулбал -0.7⁰С-аар хүйтэн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 28.4⁰С, хамгийн хүйтэн хэм 5.9⁰С, хур тунадасны нийлбэр 33.6 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 15 метр секунд хүрсэн байна.

Хүснэгт 6. Агаарын бохирдолт, мг/м³, VIII сард¹

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	379	0.068	3	0.009
Азотын давхар исэл	NO ₂	0.050	266	0.065	11	0.025
Тоосжилт	PM ₁₀	0.100	357	0.278	42	0.052
	PM _{2.5}	0.050	203	0.127	28	0.022
Нүүрстөрөгчийн дутуу исэл ²	CO	10.000	889	2.862	-	0.472
Озон	O ₃	0.100	561	0.099	-	0.043

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2021 оны 8 дугаар сард Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн дундаж агууламж 0.001 мг/м³ (6.2%)-ээр, хүхэрлэг хийн дундаж агууламж 0.006 мг/м³ (2.5 дахин)-ээр, PM 2.5 тоосонцорын дундаж агууламж 0.010 мг/м³ (92.2%)-ээр, PM 10 тоосонцрын дундаж агууламж 0.017 мг/м³ (49.4%)-ээр тус тус их байна.


Хүснэгт 7. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын агууламж агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас давсан тохиолдлын тоо, станц, 2021 оны VIII сард

Станцын байршил	Хүхэрлэг хий (SO ₂)	Азотын давхар исэл (NO ₂)	Нүүрс төрөгчийн дутуу исэл (CO)	Тоос (PM ₁₀)	Тоос (PM _{2.5})	Озон (O ₃)
Мишээл экспо	-	-	-	2	-	-
Баруун 4 зам	-	9	-	4	6	-
1-р хороолол	-	-	-	4	5	-
13-р хороолол	-	1	-	-	-	-
32-ын тойрог	-	-	-	15	-	-
Хархорин	-	1	-	7	-	-
Ургах наран хороолол	-	-	-	5	-	-
Хайлааст	-	-	-	3	4	-
248-р цэцэрлэг	-	-	-	1	7	-
Богд хааны ордон музей	-	-	-	1	3	-
Нисэх	-	-	-	-	-	-
Толгойт	-	-	-	-	1	-
Зурагт	-	-	-	-	2	-
Амгалан	3	-	-	-	-	-
Баянхошуу	-	-	-	-	-	-


¹ Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

² 8 цагийн дундаж


Зураг 7. Улаанбаатар³ хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 13 станцын дундаж, мг/м³



Зураг 8. Улаанбаатар³ хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 11 станцын дундаж, мг/м³



Зураг 9. Улаанбаатар³ хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 12 станцын дундаж, мг/м³



Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2021 оны 8 дугаар сарын 11, 12-ны өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд нитритийн нэгдэл 2.6 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 2.5 дахин, амоны азот 5.3 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 8. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, VIII сард⁴

Үзүүлэлт		Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	8.31	Хэвийн	5.05	хэвийн
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BXX ₅	≤3	2.45	Хэвийн	7.35	2.5 дахин
Нитритийн нэгдэл	NO ₂	≤0.02	0.001	Хэвийн	0.052	2.6 дахин
Амоны азот	NH ₄	≤0.5	0.23	Хэвийн	2.66	5.3 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.004	Хэвийн	0.049	хэвийн

³ Багануур, Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдол хэмжих харуул цэг байхгүй.

⁴ Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

Хүснэгт 9. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, VIII сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	I хороолол	XIII хороолол	32-ын тойрог	Хархорин зах	Ургах наран хороолол	Хайлааст	248-р цэцэрлэг	Богд хааны ордон музей	Нисэх	Толгойт	Зурагт	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.012	0.003	0.008	0.004	0.005	0.004	0.001	0.005	0.013	0.006	0.008	-	0.020	0.032
	Хамгийн их XXX*-с давсан хувь	0.046	0.010	0.023	0.021	0.021	0.015	0.004	0.009	0.032	0.020	0.026	-	0.036	0.068
	Хэмжилтийн тоо	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	10.0
	Хэмжилтийн тоо	31	31	20	31	30	31	31	29	27	31	27	-	30	30
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	0.033	0.047	0.023	0.031	0.027	0.033	0.013	0.008	0.012	0.028	-	-	-	0.020
	Хамгийн их XXX*-с давсан хувь	0.050	0.065	0.038	0.056	0.035	0.056	0.021	0.013	0.029	0.046	-	-	-	0.041
	Хэмжилтийн тоо	-	29.0	-	3.0	-	3.0	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	17	31	15	31	11	31	22	25	30	23	-	-	-	30
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.361	0.673	0.492	0.321	0.500	0.494	0.277	0.490	-	0.422	0.515	0.531	0.675	0.385
	Хамгийн их XXX*-с давсан хувь	0.661	1.499	1.341	2.465	1.421	1.353	2.862	1.119	-	1.450	1.749	1.315	1.304	0.603
	Хэмжилтийн тоо	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	27	93	92	72	93	93	29	84	-	90	75	73	35	33
Тоос PM ₁₀	Дундаж	0.040	0.051	0.060	0.044	0.099	0.087	0.060	0.051	0.041	0.040	-	0.017	0.033	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	0.159	0.173	0.192	0.100	0.229	0.278	0.208	0.191	0.143	0.125	-	0.064	0.096	-
	Хэмжилтийн тоо	6.0	13.0	13.0	-	52.0	26.0	16.0	10.0	3	3.0	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	31	31	31	31	29	27	31	29	31	31	-	25	30	-
Тоос PM _{2.5}	Дундаж	-	0.028	0.023	-	-	-	-	0.022	0.034	0.013	-	0.013	0.018	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	-	0.115	0.117	-	-	-	-	0.127	0.118	0.099	-	0.054	0.069	-
	Хэмжилтийн тоо	-	19.0	18.0	-	-	-	-	14.0	23	10.0	-	4.0	7.0	-
	Хэмжилтийн тоо	-	31	28	-	-	-	-	29	31	31	-	25	28	-
Озон O ₃ **	Дундаж	-	-	0.034	0.023	-	-	0.041	-	-	-	0.054	0.041	0.055	0.052
	Хамгийн их XXX*-с давсан хувь	-	-	0.092	0.058	-	-	0.085	-	-	-	0.099	0.082	0.091	0.089
	Хэмжилтийн тоо	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	93	93	-	-	93	-	-	-	74	90	27	91

* Хүлцэх хэм хэмжээ,

**CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Байгаль орчны зөрчил:

Нийслэлийн хэмжээнд 2021 оны эхний 8 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 157 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 12.7 хувийг ан амьтны зөрчил, 45.2 хувийг газрын зөрчил, 15.9 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 12.1 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 2.5 хувийг усны зөрчил, 4.4 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 5.1 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний зөрчил, 1.3 хувийг ойн зөрчил, 0.8 хувийг бусад зөрчил тус тус эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 303.9 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Хүснэгт 10. Байгаль орчны зөрчил, төрлөөр, 2021 оны эхний 8 сард⁵

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2020 I-VIII			2021 I-VIII		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)
Бүгд	284	284	263.7	159	157	303.9
Ой	1	1	0.3	2	2	0.6
Ан, амьтан	9	9	15.8	20	20	34.7
Газрын	111	111	133.0	71	71	117.5
Ус	-	-	-	5	4	89.0
Ургамал, хөрсний бохирдол	-	-	-	-	-	-
Агаар, химийн хорт бодис	6	6	11.1	7	7	18.3
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	37	37	47.0	20	19	19.1
Геодези зураг зүй, кадастр	72	72	12.1	25	25	10.1
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	28	28	32.0	8	8	13.6
Бусад	20	20	12.4	1	1	1.0

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2021 оны эхний 8 сард 140 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 21.8 хувиар буурсан байна. Нийт гамшигт хүчтэй салхи шуурга 2, аадар бороо, үер 1, хүний үйл ажиллагаатай холбоотой 137 осол бүртгэгдсэн байна. Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд үйлдвэрийн 1 осол, сум галт хэрэгслийн 1 осол, усны 36 осол, тэсрэх дэлбэрэх бодисын 2 осол, бусад төрлийн 97 осол бүртгэгджээ. Гамшгийн улмаас 42 хүн амь насаа алдаж, 142 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 4.4 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 11. Гал түймрийн тоо, дүүргээр, жил бүрийн эхний 8 сард


Дүүрэг	2016	2017	2018	2019	2020	2021	$\frac{2021}{2020} \%$
Нийслэлийн дүн	1 789	1 817	1 681	2 068	1 330	994	74.7
Багануур	29	24	22	34	19	19	100.0
Багахангай	6	2	3	5	4	4	100.0
Баянгол	297	263	286	256	172	135	78.5
Баянзүрх	447	411	404	503	293	237	80.9
Налайх	68	59	61	37	41	27	65.8
Сонгинохайрхан	379	405	367	522	339	234	69.0
Сүхбаатар	203	250	205	269	174	130	74.7
Хан-Уул	158	192	169	198	143	105	73.4
Чингэлтэй	202	211	164	244	145	103	71.0

Нийслэл хотод 2021 оны эхний 8 сард ахуйн 994 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 25.3 хувиар буурав. 2021 оны эхний 8 сард худал дуудлагын тоо 14 болж өмнөх оны мөн үеэс 30 дуудлагаар буюу 68.2 хувиар буурсан байна. Гал түймрийн улмаас 19 хүн (үүнээс, хүүхэд 6) амь насаа алдаж, 27 хүн түлэгдэж гэмтсэн байна.


⁵ Эх үүсвэр: НМХГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтэс

Гал түймрийн аюулаас 627 хүн, 341 байшин барилга, 57.9 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 276, санамсаргүй байдлаас 626, санаатай үйлдлээр 2, шалтгаан тогтоогдоогүй 3, бусад шалтгаанаар 87 гал түймэр гарчээ.

Зураг 10. Гал түймэр, байршлаар



Зураг 11. Гал түймэр, шалтгаанаар



Гал түймэрт 564 гэр, орон сууц, 44 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 88 машин техник, малын 8 хашаа, саравч, бусад төрлийн 290 объект өртжээ. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 698, төрийн өмчийн 243, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 53 объект өртөж, нийт 2164.9 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2021 оны эхний 8 сард 87 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 281 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 10273 айл өрх, 5978 объектод үзлэг шалгалт хийж, 15882 галын зөрчил илрүүлж, байгууллага, албан тушаалтан, иргэнд 1179 заавал биелүүлэх албан шаардлага, 1608 мэдэгдэл хүргүүлж, 48.6 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



ГЭМТ ХЭРЭГ (2021 оны эхний 8 сард)

ᠭᠡᠮᠡᠲᠤ ᠬᠡᠷᠡᠭ



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүргээр)


2020 VIII

11 607

2021 VIII

9 499

18.2% ↓



↓ ↑ Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хувиар

Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

9 221



Гэмтсэн хүн

2 732



Нас барсан хүн


179

ГЭМТ ХЭРЭГ

2021 оны эхний 8 сард 9499 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2108 (18.2%) хэргээр, гэмт хэргийн илрүүлэлт 41.4 хувьтай байгаа нь 0.8 пунктээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 2732 хүн гэмтэж осолдон, 179 хүн нас барж, төр ард иргэдэд 92.7 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 37.1 тэрбум (40.0%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Зураг 12. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 30.9 хувийг залилан, 28.6 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 18.5 хувийг хулгайн, 2.6 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.6 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 1.7 хувийг дээрмийн, 1.6 хувийг хүчин, 0.8 хувийг хүн амь, 1.4 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 12.3 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, жил бүрийн эхний 8 сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт, 2021/2020	
	2019 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	15 329	11 607	9 499	-2 108	-18.2
Хүний амь	76	67	75	8	11.9
Хүчин	183	143	147	4	2.8
Дээрэм	613	292	165	-127	-43.5
Хулгай	5 036	3 399	1 761	-1 638	-48.2
Залилан	3 162	2 770	2 938	168	6.1
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	3 542	3 066	2 719	-347	-11.3
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	422	277	244	-33	-11.9
Бусдыг амиа хорлоход хүргэх	190	123	130	7	5.7
Ашиглах	262	191	148	-43	-22.5
Танхайрах	15	6	3	-3	-50.0
Бусад	1 828	1 273	1 169	-104	-8.2

2021 оны эхний 8 сард 34623 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15454 (30.0%) хүнээр буурсан байна.

Хүснэгт 13. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр, жил бүрийн эхний 8 сард

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2021/2020	
	2019 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	15 329	11 607	9 499	-2 108	-18.2
Багануур	128	102	108	6	5.9
Багахангай	13	16	15	-1	-6.3
Баянгол	2 427	1 833	1 516	-317	-17.3
Баянзүрх	4 096	3 281	2 473	-808	-24.6
Налайх	238	251	171	-80	-31.9
Сонгинохайрхан	2 666	1 723	1 710	-13	-0.8
Сүхбаатар	2 446	1 949	1 282	-667	-34.2
Хан-Уул	1 465	1 161	1 191	30	2.6
Чингэлтэй	1 850	1 291	1 033	-258	-20.0


2021 оны эхний 8 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 8487 (89.3%) нь хөнгөн хэрэг, 1012 (10.7%) нь хүнд хэрэг байна.⁶

Хүснэгт 14. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2021 оны эхний 8 сар

Дүүрэг	Хэрэг бүртгэлтийн Хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг	
Нийслэлийн дүн	6 290	2 602	40.2
Багануур	64	30	47.0
Багахангай	3	-	0.0
Баянгол	1 066	516	48.0
Баянзүрх	1 703	706	40.0
Налайх	49	23	42.6
Сонгинохайрхан	1 063	484	42.6
Сүхбаатар	686	233	33.2
Хан-Уул	945	391	40.7
Чингэлтэй	711	219	30.5

⁶ Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж 2 ангилдаг болсон.

Зураг 13. Гэмт хэргийн илрүүлэлт, 2021 оны эхний 8 сард



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2021 оны эхний 8 сард 5836 болж, өмнөх оны мөн үеэс 375 (6.0%) хүнээр буурсан байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 1389 (23.8%) нь согтуугаар, 714 (12.2%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 289 (4.9%) нь хүүхэд, 1336 (22.9%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 15. Бүртгэгдсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, жил бүрийн эхний 8 сард

Дүүрэг	Хулгайн гэмт хэргийн тоо, бүгд			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2019 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII
Нийслэлийн дүн	5 036	3 399	1 761	4 537	3 032	1 507
Багануур	29	17	9	24	15	8
Багахангай	2	3	2	2	3	2
Баянгол	705	384	290	613	297	218
Баянзүрх	1 465	1 043	464	1 310	881	392
Налайх	67	56	14	65	51	14
Сонгинохайрхан	959	625	358	904	602	334
Сүхбаатар	774	555	234	701	508	199
Хан-Уул	408	358	218	350	339	197
Чингэлтэй	627	358	172	568	336	143

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.


Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж




ТӨСӨВ (2021 оны эхний 8 сард)


ᠭᠠᠨᠠᠨᠠ



Төсвийн орлого, зарлагын бүтэц



■ Татварын орлого
■ Татварын бус орлого



■ Урсгал зардал
■ Хөрөнгийн зардал


НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн төсвийн нийт орлого 2021 оны эхний 8 сард 709.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 43.0 тэрбум төгрөгөөр (5.7%) дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 92.1 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 7.9 хувийг татварын бус орлого эзэлж байна.

2021 оны эхний 8 сард нийслэлийн татварын орлого 653.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 36.6 тэрбум төгрөгөөр (5.3%), татварын бус орлого 55.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 6.5 тэрбум төгрөгөөр (10.6%) тус тус дутуу бүрдсэн байна.

Орлогын албан татвар төлөвлөснөөс 31.9 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 10.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрджээ.

Зураг 14. Нийслэлийн төсвийн орлого, сая төгрөг



Хүснэгт 16. Нийслэлийн төсвийн орлого, дүүргээр, сая төгрөг

Дүүрэг	Үүнээс:									
	Төсвийн орлого			Татварын орлого			Татварын бус орлого			Өмч хувьчлал
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Гүйцэтгэл
Нийслэлийн дүн	752 595.5	709 521.3	94.3	690 374.3	653 694.8	94.7	62 221.3	55 640.8	89.4	185.7
Багануур	1 593.9	2 095.0	131.4	1 097.6	1 546.0	140.9	496.3	549.0	110.6	-
Багахангай	274.3	340.5	124.1	89.8	79.1	88.1	184.5	261.5	141.7	-
Баянгол	23 071.5	24 236.6	105.0	21 239.8	22 649.2	106.6	1 831.7	1 587.4	86.7	-
Баянзүрх	30 584.5	39 793.2	130.1	29 447.3	38 996.0	132.4	1 137.1	797.3	70.1	-
Налайх	1 658.7	2 328.0	140.4	1 310.2	1 891.0	144.3	348.5	437.0	125.4	-
Сонгинохайрхан	14 132.1	16 014.1	113.3	13 430.7	15 402.6	114.7	701.5	611.6	87.2	-
Сүхбаатар	52 331.3	53 073.1	101.4	51 038.4	51 602.3	101.1	1 293.0	1 470.7	113.7	-
Хан-Уул	50 734.9	43 236.7	85.2	48 887.5	41 483.0	84.9	1 847.4	1 753.6	94.9	-
Чингэлтэй	41 956.3	70 550.6	168.2	40 609.3	69 407.1	170.9	1 347.0	1 143.5	84.9	-
Хотын шууд	536 258.0	457 853.5	85.4	483 223.7	410 638.5	85.0	53 034.3	47 029.3	88.7	185.7

Хүснэгт 17. Нийслэлийн төсвийн орлого, сая төгрөг


Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
Нийт орлого	752 595.5	709 521.3	94.3
1. Татварын орлого	690 374.3	653 694.8	94.7
Орлогын албан татвар	500 677.7	468 708.8	93.6
Хувь хүний орлогын албан татвар	528 677.7	486 398.6	92.0
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	382 000.0	323 935.5	84.8
Үйл ажиллагааны орлогын	28 889.7	25 424.3	88.0
Хөрөнгийн орлого	66 330.7	73 672.7	111.1
Хөрөнгө борлуулсны орлогын	8 478.3	32 560.4	3**
Шууд бус орлого	42 979.0	30 805.7	71.7
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-28 000.0	- 17 689.8	63.2
Хөрөнгийн албан татвар	80 872.0	62 086.9	76.8
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	48 816.7	34 492.3	70.7
Бууны албан татвар	274.3	175.2	63.9
Малд ногдуулах албан татвар	31.0	0.0	0.0
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	31 750.0	27 419.4	86.4
Бусад татвар, төлбөр, хураамж	108 824.6	122 899.1	112.9
Бусад нийтлэг төлбөр, хураамж	33 843.6	65 553.4	193.7
Газрын төлбөр	67 538.4	52 226.7	77.3
Байгалийн нөөц ашигласны төлбөр	2 717.6	1 961.7	72.2
Бусад татвар	4 725.0	3 157.3	66.8
2. Татварын бус орлого	62 221.3	55 640.8	89.4
Нийтлэг татварын бус орлого	62 221.3	55 640.8	89.4
Хувьцаа ногдол ашиг, Хүүгийн орлого	141.0	12.5	8.9
Төсөвт байгууллагын өөрийн орлого	9 049.2	4 464.9	49.4
Торгуулийн орлого	34 533.0	33 933.0	98.3
Түрээсийн орлого	1 319.0	1 246.6	94.5
Бусад орлого	17 179.1	15 983.8	93.0
3. Өмч хувьчлал	0.0	185.7	-

2021 оны эхний 8 сард нийслэлийн төсвөөс нийслэл, дүүргийн байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 55.2 хувийг (723.5 тэрбум төгрөг) санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл нийслэл, дүүргийн байгууллагууд батлагдсан төсвийнхөө 44.8 хувийг (586.6 тэрбум төгрөг) зарцуулаагүй байна.


Хүснэгт 18. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг

Дүүрэг	Зарлага			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нийслэлийн дүн	1 310 163.6	723 507.3	55.2	586 656.3
Багануур	15 305.9	13 143.4	85.8	2 162.5
Багахангай	4 684.7	4 081.5	87.1	603.2
Баянгол	68 514.2	58 342.8	85.2	10 171.4
Баянзүрх	102 710.0	84 972.5	82.7	17 737.5
Налайх	16 892.3	15 018.6	88.9	1 873.7
Сонгинохайрхан	90 230.0	74 358.2	82.4	15 871.8
Сүхбаатар	116 893.0	90 107.4	77.1	26 785.7
Хан-Уул	96 757.7	69 084.0	71.4	27 673.6
Чингэлтэй	76 176.1	60 508.5	79.4	15 667.5
Хотын шууд	721 999.7	253 890.4	35.2	468 109.4

Зураг 15. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг



Зураг 16. Нийслэлийн төсвийн орлого, зарлага, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.


Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (2021 оны 8 дугаар сард)

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Ерөнхий индекс




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өслөө.

2021 оны 8 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2020 оны эцэстэй харьцуулахад 10.0 хувь, өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар тус тус өссөн байна.

Зураг 17. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2021 онд өмнөх оны эцэстэй харьцуулахад 10.0 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 13.0 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 3.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 25.8 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 1.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ бүлгийн үнэ 6.0 хувь, тээвэр бүлгийн үнэ 15.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 0.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 1.2 хувь, боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ 5.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 14.3 хувь, бусад бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 4.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 19. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр


Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2020-VIII</u> 2019-VIII	<u>2021-VIII</u> 2020-VIII	<u>2021-VIII</u> 2020-XII	<u>2021-VIII</u> 2021-VII
Ерөнхий индекс	101.7	109.1	110.0	100.1
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	103.2	112.8	113.0	97.1
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	105.2	104.1	103.5	100.5
Хувцас, бөс бараа, гутал	103.6	101.7	99.3	100.4
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	102.3	108.6	125.8	102.7
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.7	103.0	101.7	100.1
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	102.9	107.4	106.0	101.0
Тээвэр	93.6	118.2	115.4	101.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.2	100.4	100.4	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.3	101.9	101.2	100.6
Боловсролын үйлчилгээ	100.6	105.6	105.6	104.7
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	104.8	115.6	114.3	101.3
Бусад бараа, үйлчилгээ	106.0	106.1	104.5	101.6

2021 оны 8 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 27.0 хувийнх нь үнэ өсөж, 11.1 хувийнх нь үнэ буурч, 61.9 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.


Хүснэгт 20. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс, /**аерэг**, **сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	2.9	Энэ бүлгийн үнийн бууралтад мах, махан бүтээгдэхүүний үнэ 6.7 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 4.3 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлөв.
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	0.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд архи, спиртны үнэ 1.7 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	0.4	Хувцас, бөс бараа, гуталын бүлгийн үнийн өсөлтөд бүх төрлийн хувцасны үнэ 0.6 хувиар, хувцас засвар, цэвэрлэгээ, түрээсийн үнэ 2.2 хувиар өссөн нь тус тус нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	2.7	Энэ бүлгийн үнийн өсөлтөд сууц хөлслөгчийн төлсөн бодит түрээсийн үнэ 3.2 хувиар, орон сууцны техникийн болон засвар үйлчилгээний үнэ 6.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.
